



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 9/16

Хархорин сум

Г Т

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ц.Мягмарсүрэн (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Баатарсүрэн (Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Ч.Баттулга (Газрын даамал)

Э.Очир-Эрдэнэ (Архитектор)

Д.Оюун-Эрдэнэ (Иргэний төлөөлөл)

А.Ганболд (Ахмадын хорооны дарга)

Нарийн бичгийн дарга: Н.Нямдаваа (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2. Багуудаас ирүүлсэн саналыг холбогдох журмын дагуу нэгтгэн эрэмбэлж, зөвлөмж, дүгнэлт гаргаж танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА ГОДГЭРЭЛ



401100031